



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТИН ГАЗАР

АЭДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2024.08.01 № 01/641  
танай -ны № -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЦЭЦЭРЛЭГ  
СҮМЫН АРДЧИЛСАН НАМЫН  
ХОРООНЫ ДАРГА Н.АНХБАЯР  
ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх  
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын Ардчилсан намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

### Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

### Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

### Дүгнэлт

Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын Ардчилсан намын хорооны Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд

оролцооор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага болон холбогдох бусад хууль, тогтоомжид тус тус нийцсэн байна.

Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын Ардчилсан намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөр (12 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын Ардчилсан намын хороонд

Хувийг: Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын Сонгуулийн хороонд

Хавсралт . . . хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР



**СОНГУУЛЬ-2024**  
**ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЦЭЦЭРЛЭГ**  
**СУМЫН АРДЧИЛСАН НАМЫН**  
**ХОРООНЫ 2024 ОНЫ ОРОН**  
**НУТГИЙН СОНГУУЛИЙН МӨРИЙН**  
**ХӨТӨЛБӨР**

2024он



000000001

Эрхэм зорилго:

**“ХҮНЭЭ ДЭМЖИЖ, СУМАА ХӨГЖҮҮЛЬЕ”**

Хөтөлбөрийн зорилго:

**Нэг.** Хүний хөгжил, хэрэгцээг хангах ажил үйлчилгээгээр иргэдийн амьдралд дэвшил, өөрчлөлт гаргана.

**Хоёр.** Иргэдийн хэрэгцээ, санал санаачилгад тулгуурласан хөгжлийн бодлогоор сумаа хөгжүүлнэ.


**Гурав.** Иргэдийнхээ эрх ашгийг дээдэлсэн төрийн ил тод, шуурхай үйлчилгээг төлөвшүүлнэ.

**НЭГ. ХҮН АМЫН ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГО**

**1.1 Эрүүл мэндийн бодлого**

Иргэдийн эруул мэндийн боловсролыг дээшлүүлж, эмнэлгийн тусlamж үйлчилгээний чанар хүrtээмжийг сайжруулна.

- 1.1.1 Эмнэлгүүдийг нэн шаардлагатай багаж, тоног төхөөрөмжөөр хангаж, стандартын шаардлага хангасан эмнэлгийн барилга барьж ашиглалтад оруулах
- 1.1.2 Эрүүл мэндийн байгууллагуудын автомашины паркийг сайжруулж, багийн бага эмчийг мотоциклоор хангаж, явуулын эмийн санг бий болгоно
- 1.1.3 “Эрүүл хүүхэд” аяны хүрээнд хийгдсэн судалгааг үргэлжлүүлэн, судалгаанд үндэслэн шүдний кабинет ажиллуулж цэцэрлэг, сургуулиудын хүүхдийн шүд, амны хөндийг эрүүлжүүлэх ажлыг системтэйгээр зохион явуулна
- 1.1.4 Эмч, эмнэлгийн ажилтны мэдлэг, ур чадварыг тасралтгүй дээшлүүлж, ёс зүйн хариуцлагыг өндөржүүлнэ
- 1.1.5 Халдварт өвчин ялангуяа А гепатит шар өвчнөөс урьдчилан сэргийлэх, түүний гаралтыг зогсооход бусад мэргэжлийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлнэ.
- 1.1.6 Нөхөн үржихүйн насны эрсдэлт бүлгийн болон задгай талбайд худалдаа эрхэлдэг эмэгтэйчүүдийг эрүүлжүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлж ажиллана.
- 1.1.7 Хүн амын эрүүл аж төрөх, эрүүл мэндээ хамгаалах зан үйлийг төлөвшүүлэн, хүүхэд залуучуудад эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийнхээ төлөө хүлээх гэр бүлийн хариуцлагыг дээшлүүлэх, ард иргэдийн дунд эмийн зохистой хэрэглээг сурталчлах ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.
- 1.1.8 Эрүүл мэндийг дэмжигч орчинд суурилсан урамшууллын тогтолцоог хэрэгжүүлж, эрүүл мэндийг дэмжигч байгууллага хамт олны тоог нэмэгдүүлнэ.
- 1.1.9 Сүүлийн жилүүдэд зонхилон тохиолдож байгаа чихрийн шижин өвчнөөс урьдчилан сэргийлж, эрт илрүүлэх эмчлэх ажлыг эрчимжүүлнэ.
- 1.1.10 ЭМТ дээр анхан шатны оношилгоо шинжилгээний лаборатори байгуулж, иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний чанар хүrtээмжийг нэмэгдүүлнэ.



0000000002

1.1.11 ЭМТ-д ажиллахаар шинээр төгсөн ирж буй эмнэлгийн салбарын ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх тал дээр онцгой анхаарна.

1.1.12 Эмнэлгийн тусгай мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх ажлыг бодлогоор дэмжинэ.

1.1.13 Хувийн эмнэлгийн салбар байгуулах санаачилгыг бодлогоор дэмжинэ.


## 1.2 Боловсролын бодлого

### Боловсролын шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлж,

### сургалтын таатай орчинг бүрдүүлнэ.

- 1.2.1 Бүрхээр багт шинээр цэцэрлэг барих, мөн цэцэрлэгүүдийн гадаад болон дотоод тохижилтыг ээлж дараатай хийж гүйцэтгэнэ.
- 1.2.2 Сумын төвийн цэцэрлэгийн сантехникийн шугамд их засвар хийж, цэцэрлэгүүдийн тоглоом наадгай болон сургалтын хэрэглэгдэхүүний хангамж, гадна тоглоомын талбайг сайжруулан, хүүхдийн ая тухтай сурч хүмүүжих орчныг бүрдүүлнэ.
- 1.2.3 Бага насны хүүхдийг бүх талаар өв тэгш хөгжүүлэх боломжийг бүрдүүлж цэцэрлэгүүдийн дэргэд төрөл бүрийн дугуйлангуудыг хичээллүүлэн, “Ирээдүй бидний гар” урлагийн наадмыг жил бүр уламжлал болгон зохион байгуулна.
- 1.2.4 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг СӨБ-д хамрагдах нөхцөлийг бүрдүүлж хамрагдалтыг нэмэгдүүлнэ.
- 1.2.5 Шинээр баригдаж байгаа 320 хүүхдийн сургуулийг ашиглалтад оруулж, сургуулиудын хичээлийн ээлжийн коэффициентыг бууруулна.
- 1.2.6 ЕБС-ийн сургуулийн спорт залны их засварыг хийж гүйцэтгэнэ.
- 1.2.7 Суурь боловсролын хамран сургалтыг 95,0 хувьд хүргэж, сумын “Сургалтын чанар” дэд хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, сургалтад бага дунд боловсролын шинэчилсэн хөтөлбөрийн арга зүйг нэвтрүүлнэ.
- 1.2.8 Сургууль, цэцэрлэгүүдийн гал тогооны хэрэгсэл, тоног төхөөрөмж, гар угаалтуур, ариун цэврийн байгууламжуудыг сайжруулж, эрүүл ахуйн шаардлага хангасан боловсон суултуур, гар угаалтуураар хангаж, “Үдийн хоол” хөтөлбөрийн хэрэгжилтийг чанаржуулна.
- 1.2.9 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр баригдах 150 хүүхдийн дотуур байрыг чанартай гүйцэтгүүлж ашиглалтад оруулах, дотуур байрнуудын хатуу зөвлөн эдлэлийг үе шаттайгаар шинэчилж, хүүхдийн амьдрах ая тухтай нөхцөлийг бүрдүүлнэ
- 1.2.10 Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн компьютерын хангамжийг нэмэгдүүлж, 2 сургуулийг интернэтэд холбон “Цахим сургууль- Цахим сургалт” хөтөлбөрийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.
- 1.2.11 Ерөнхий боловсролын сургуулиудын дэргэд секц, дугуйлангуудыг тогтмол хичээллүүлж, урлаг спортын авьяасыг нээн илрүүлж, оюуны чадавхыг хөгжүүлнэ.
- 1.2.12 Сургууль, цэцэрлэгийг “Эрүүл мэндийг дэмжигч байгууллага” болох хөдөлгөөн өрнүүлнэ.

172090001 в 7670606




0000000003

- 1.2.13 Насан туршийн боловсролын “Гэгээрэл” төвийн сургалтын орчныг бэхжүүлж, үйл ажиллагааг нь өргөтгөн дэмжлэг үзүүлж ажиллана.
- 1.2.14 Хүүхэд багачуудад эх оронч үзлийг бий болгох зорилгоор “Хилчин” танхимыг байгуулж, үе шаттай тохижилтын ажлыг хийнэ.
- 1.2.15. Хүүхдийн ордны сургалтын хэрэглэгдэхүүний хангамжийг сайжруулж, амьдрах ухаанд суралцах дугуйланг хичээллүүлэн хүүхдийг бүхий л талаар хөгжих нөхцөлийг бүрдүүлнэ.
- 1.2.16. Хүүхдийг тодорхой зорилго чиглэлтэй амьдрах, эх орноо хайрлах үзэл баримтлалаар хүмүүжүүлж, нийгэмд зөв иргэн болж төлөвшүүлэхэд анхаарч хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын үйлчилгээг сайжруулна.
- 1.2.17. Хүүхдийн эрүүл агаарт чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор стандартын шаардлага хангасан хүүхдийн тоглоомын талбайг барьж, өвлийн спортын талбай байгуулах санал санаачилгыг дэмжиж ажиллана.
- 1.2.18 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдэж буй ЕБС-ийг хүүхэд тээвэрлэх авто машиныг зориулалтын дагуу ашиглуулна.
- 1.2.19 Цэцэрлэг, сургуульд экологийн танхим, булан байгуулна.
- 1.2.20 Олон хувилбарт сургалтыг төрөл хэлбэрийг олшруулан, сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг 90 хувьд хүргэнэ.
- 1.2.21 Сургуульд шинээр төгсөн ирж буй багш болон өндөр ур чадвар сайтай багш нарт нийгмийн асуудлыг шийдвэрлэх тал дээр онцгой анхаарна.

### **1.3 Соёл, спорт, аялал жуулчлалын бодлого**

Үндэсний урлаг, соёл, аялал жуулчлал, нийтийн биеийн тамир, спортын ажил, үйлчилгээний чанар, хүртээмжийг иргэд, олон нийтийн эрэлт хэрэгцээнд нийцуулэн сайжруулна.

- 1.3.1 Соёлын төв жилд 2-оос доошгүй шинэ уран бүтээлээр урын сангаа баяжуулан олны хүртээл болгох, алслагдсан баг хөдөөгийн иргэдэд үзүүлэх явуулын үйлчилгээг сайжруулна.
- 1.3.2 Соёлын салбарт ажиллагсдын мэдлэг чадварыг тасралтгүй дээшлүүлэн, мэргэжлийн ажилтнаар ханган, соёл урлагийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулна.
- 1.3.3 Соёлын байгууллагад шаардлагатай хувцас, хөгжмийн зэмсэг, техник тоног төхөөрөмжөөр хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- 1.3.4 Соёлын төвийг түшиглэн түшиглэн хүүхэд залуучуудын дунд урлагийн бүх төрлийн дугуйланг чанартай тогтмол хичээллүүлэн, авьяас чадварыг хөгжүүлнэ.
- 1.3.5 Орон нутаг судлах музейн үйл ажиллагааг тогтмолжуулж, соёлын үнэт зүйл, өвийг хадгалж хамгаалах ажлыг сайжруулна



0000000004

- 1.3.6 Жилд 1 удаа урлаг соёл, эрүүл мэнд, төрийн үйлчилгээг иргэдэд ойрхон хүргэх багийн өдөрлөгийг зохион байгуулж хэвшинэ.
  - 1.3.7. Номын сангудын үйлчилгээг өргөжүүлж, номын сангийн үйл ажиллагаанд орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэн, “Цахим номын сан” болгох ажлыг эрчимжүүлэн, номын фондын баяжилтыг нэмэгдүүлнэ.
  - 1.3.8. Соёл спортын цогцолборыг барьж ашиглалтад оруулах, улмаар мэргэжлийн боловсон хүчний орон тоог шийдвэрлүүлж, спортын холбоо клубуудын үйл ажиллагааг дэмжин нийтийн биеийн тамир, спортоор хичээллэгсдийн тоог нэмэгдүүлнэ.
  - 1.3.9. Иргэдийн биеийн тамир спортоор хичээллэх, аюулгүй таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх, багийн спортын зориулалтын талбай байгуулах санал санаачилгыг дэмжинэ.
  - 1.3.10. Хүүхэд, залуучуудын соёл, спортын цогцолборын задгай байгууламжийг шинээр барьж ашиглалтад оруулна.
  - 1.3.11. Залуучуудын байгууллагын санаачилгыг дэмжих, залуучуудын авьяас сонирхлыг хөгжүүлэх, чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэхэд зориулсан төрөл бүрийн клуб байгуулах санал санаачилгыг дэмжинэ.
  - 1.3.12. Аялал жуулчлалын цогц бодлого боловсруулж байгалийн унаган төрхийг хэвээр хадгалах, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх, аяллын шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгоход дэмжлэг үзүүлж, иргэд ААН-ийг дэмжинэ.
  - 1.3.13. Амралт сувиллын газрын газар олголтыг хийж, өрсөлдөх чадвар чадвар бүхий рашаан сувилал, амралтын газрыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
  - 1.3.14. Соёлын өв, түүх соёлын дурсгалт газар, хэрэгсүүр, булш бунхан, овоо тахилтай газрыг бүртгүүлж нутгийн иргэдийг түшиглэн хамгаалалтад авах ажлыг үргэлжлүүлэх, “Тэсийн гол” дэд хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.

#### **1.4 Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын бодлого**

**Нийгмийн хамгааллын үйлчилгээний чанар, хуртээмжийг сайжруулан,  
хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.**

- 1.4.1. Хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл, хөдөлмөр зуучлалын үйлчилгээг чанаржуулж, хөдөлмөрийн бирж ажиллуулж, түр болон бүр шинэ ажлын байр бий болгоно.
  - 1.4.2. Ажилгүй иргэдийг мэргэжил олгох болон давтан сургалтад хамруулан мэргэжлийн зөрүүгээс ажилгүйдэл үүсэх шалтгааныг бууруулна.
  - 1.4.3. Нийтийг хамарсан ажлыг зохион байгуулж, жилд 50-аас доошгүй идэвхтэй ажлын байр хайгчдыг түр ажлын байраар хангана.
  - 1.4.4. “Ахмадын өргөө”-ний байрны их засварын хийж, тав тухтай орчинд үйл ажиллагаа явуулах боломжийг бүрдүүлж, тэдэнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хуртэмжийг сайжруулна.

172009001-201605



0000000065

- 1.4.5. Орон сууц, сургууль, цэцэрлэг болон үйлчилгээний газарт хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийг байгуулан, тэдний ажиллах нөхцөл боломжийг харгалzan хатгамал, бэлэг дурсгалын зүйл хийх цех бий болгох санал санаачилгыг дэмжиж ажиллана.
- 1.4.6. Зорилтот бүлгүүдэд чиглэсэн нийгмийн халамжийн бодлогыг хэрэгжүүлнэ.
- 1.4.7. Улсын бүртгэлийн хэлтэст бүртгэлтэй боловч нийгмийн даатгалд хамрагдаагүй, мөн шинээр байгуулагдсан аж ахуйн нэгж байгууллагууд, малчид, албан бус секторт хөдөлмөр эрхлэгчид, ажилгүй иргэд, жижиг аж ахуй эрхлэгчдийг нийгмийн даатгалд хамруулах ажлыг зохион байгуулна.
- 1.4.8. Үйлдвэрлэл, өрхийн аж ахуй эрхлэх хүсэлтэй иргэдийг зээл хөтөлбөрт хамруулан өрхийн амьжиргааны түвшнийг сайжруулна.
- 1.4.9. Ахмад настан, асаргаа шаардсан өвчтөн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан гэрийн тусlamж үйлчилгээг бий болгох мэргэжлийн багийн санал санаачилгыг дэмжинэ.
- 1.4.10. Ахмадуудын чадамжид суурилсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор төсөл хөтөлбөрт хамруулна.
- 1.4.11. Ахмад настныг нийгмийн амьдралд идэвхтэй оролцуулах, тэдний амьдралын туршлага мэдлэг чадварыг залуу үеийнхэнд өвлүүлэх зорилгоор сумын засаг даргын дэргэд "Ахмад мэргэжилтнүүд"-ийн зөвлөл байгуулна.
- 1.4.12. Мэргэжлийн байгууллагаар сумын хөдөлмөр эрхлэлтийн талаарх бодлогыг тодорхойлуулж, үр дүнтэй ажлуудыг зохион байгуулах

## ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

### 2.1 Хөдөө аж ахуйн бодлого

Мал аж ахуй, газар тариалангийн эрчимжүүлэлтийг нэмэгдүүлж, нэгжээс авах ашиг шимээр аймагтаа тэргүүлж, баталгаат хүнсний хангамжийг нэмэгдүүлнэ.

- 2.1.1. Усалгаатай газар тариалангийн хувийн жинг өсгөж, нэгж талбайгаас авах ургацын хэмжээг нэмэгдүүлнэ.
- 2.1.2. Төмс хүнсний ногоо тариалагч иргэдийг бага оврын техникээр хангаж, хөдөө аж ахуйд ашиглагдаж байгаа техник тоног төхөөрөмжийг шинэчлэх бодлогыг барина.
- 2.1.3. Төмс хүнсний ногоо тариалагчдыг хоршоо, бүлгийн зохион байгуулалтад оруулж, сав баглаа боодлыг шошгожуулан "Цэцэрлэг брэнд" бий болгон, "Хаалганаас хаалганд" хөтөлбөрийг боловсруулан, хэрэгжүүлж, сүлжээ дэлгүүрт борлуулах ажлыг хэрэгжүүлнэ.
- 2.1.4. Хүлэмж, зоорины аж ахуйг хөгжүүлж, тариалах ургамлын нэр төрлийг олшруулан, үрийн бодлогоор дэмжиж ажиллана.
- 2.1.5. Мал амьтдын ялгадсыг ашиглан бордооны жижиг үйлдвэр байгуулж, био бордоо үйлдвэрлэж, зах зээлд борлуулах ажлыг дэмжинэ

1720000014 70005


0000000006

- 2.1.6. “Чинээлэг малчин”, “Хариуцлагатай малчин” хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ыг орон нутгийн онцлог, малчдын оролцоонд тулгуурлан хэрэгжүүлнэ.
- 2.1.7. Мал сүргийн эрүүл мэндийг хамгаалах ажлыг тогтмолжуулж, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг чанаржуулна.
- 2.1.8. Малчдын хоршоо үүсгэн байгуулах аяныг өрнүүлж тэдний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.
- 2.1.9. Бэлчээрийн болон эрчимжсэн МАА-н бүсийг шинэчлэн тогтоож фермерүүдийг төвлөрүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авна.
- 2.1.10. Үржлийн малын үзэсгэлэн худалдааг тогтмолжуулж, малын төрөл хоорондын зохистой харьцааг бурдүүлж, цэвэр болон эрлийз малын тоог нэмэгдүүлнэ.
- 2.1.11. Хувийн хэвшлийн үржлийн нэгж байгуулах ажлыг бодлогоор дэмжин, шилмэл үүлдрийн хээлтүүлэгчээр сүргийн бүтцэд сэлгэлт хийн, малын чанар ашиг шимиийг сайжруулан, сумын малчдын мал сүргийг сайн үүлдрийн эцэг малаар хангана.
- 2.1.12. Бэлчээрийг хортон мэрэгчдээс хамгаалах, бордох, усжуулах, хадлангийн талбайг хашаалах, олон наст ургамал тариалах арга хэмжээг жил бүрийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ.
- 2.1.13. Мал аж ахуйн гаралтай түүхий эдийг боловсруулах, борлуулах, малчдын бүлэг, хоршоог дэмжин, сүү боловсруулах жижиг, дунд үйлдвэрийг байгуулан, борлуулалт хийх газруудтай түншлэлийн гэрээний дагуу байнгын зах зээлээр хангаж ажиллана.

## 2.2 Үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний бодлого

Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн тоо хэмжээг нэмэгдүүлж,  
худалдаа, үйлчилгээний соёлч чанар, хүртээмжтэй үйлчилгээг стандартын  
шаардлагад нийцуулнэ.

- 2.2.1 Гар урлалын бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг жижиг үйлдвэр, цехийг байгуулах санаачилгыг дэмжинэ.
- 2.2.2 Сүү сүүн бүтээгдэхүүн, ноос ноолуур, арьс ширний анхан шатны боловсруулалт хийх зэрэг МАА-н гаралтай бүтээгдэхүүн боловсруулах жижиг, дунд үйлдвэрийг байгуулах санал санаачилгыг дэмжинэ.
- 2.2.3 Суманд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжиж сурталчлан “Цэцэрлэгт үйлдвэрлэв” үзэсгэлэн худалдааг жил бүр зохион байгуулна.
- 2.2.4. Хүнсний ногоо боловсруулах, савлах үйлдвэр байгуулах иргэдийн санал санаачилгыг дэмжинэ
- 2.2.5. Эрүүл ахуйн шаардлага хангасан, орчин үеийн тохилог ахуй, үйлчилгээ, худалдааны цогцолбор төв байгуулах саналыг дэмжинэ.
- 2.2.6. Хүн амын хүнсний хангамж, түүний аюулгүй байдалд тавих төрийн хяналтыг тогтмолжуулан зориулалтын лабораторитой болох асуудлыг дээд шатны байгууллагад уламжлан шийдвэрлүүлнэ.



1720090112 01605


0000000007

- 2.2.7. Хаягдалгүй технологи ашиглан мод боловсруулах үйлдвэр байгуулах саналыг дэмжин зүймэл , наамал, шахмал хавтанг барилгын салбарт нийлүүлнэ.
- 2.2.8. Max бэлтгэлийн төвийн тоног төхөөрөмжийг орчин үеийн шаардлагад нийцүүлэн шинэчилж үйл ажиллагааг нь өргөжүүлнэ.
- 2.2.9. Чацаргана, жимс жимсгэнэ, зөгийн аж ахуй зэрэг мал, ургамлын гаралтай түүхий эдийг түшиглэсэн анхан шатны боловсруулах үйлдвэрлэл эрхлэгчдийг бодлогоор дэмжинэ.
- 2.2.10. МАА-н гаралтай дайвар бүтээгдэхүүний цех байгуулах санаачилгыг дэмжинэ.

### 2.3 Дэд бүтэц

#### Дэд бүтцийн төлөвлөлтийг сайжруулж, хот тосгоноо хөгжүүлнэ.

- 2.3.1 Цэцэрлэг сумын 2030 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийж, Бүрхээр багийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинээр хийлгэнэ.
- 2.3.2 Хөдөөгийн багуудад жижиг гол горхины дээр авто машин гарах зориулалттай гүрүүдийг барина.
- 2.3.3 Цэцэрлэг сумын инженерийн нэгдсэн шугам сүлжээг цогцоор шийдвэрлэхэд судалгаа, зураг төслийг хийж, зохих дээд шатны байгууллагад уламжилж шийдвэрлүүлэх, "Тэсийн Илч" ХХК-ын халаалтын зуух, шугамыг өргөтгөх, нүүлгэх ажлыг хийнэ.
- 2.3.4 Сумын төвд 1 км асфальт /цемент/ замтай болгож, гэр хорооллын гудамж замууд болон бүрхээр багийн гудамжны замыг үе шаттайгаар сайжруулна.
- 2.3.5. Сумын төвд Мод толгой хороололд үерийн даланг хийж гүйцэтгэнэ.
- 2.3.6. Авто вокзал барих санал санаачилгыг дэмжиж ажиллана.
- 2.3.7. Хот, тосгоны доторх замын дагуу гэрэлтүүлгийг нэмэгдүүлж, замын тэмдэг тэмдэглэгээг сайжруулна.
- 2.3.8. Тэсийн гол дээр 40 тн-ын даацтай төмөр бетонон гүүр барих ажлын зураг төслийг хийлгүүлж, төсвийг улсын төсөвт суулгуулах ажлыг зохион байгуулна.
- 2.3.9. Засгийн газрын "Амины орон сууц" төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд эко болон уламжлалт технологийн орон сууцны хотхон байгуулах санал санаачилгыг бүх талаар дэмжинэ.
- 2.3.10 Олон жил ашиглагдсан нийтийн орон сууц болон төрийн байгууллагуудын барилгуудын дээвэр, гадна дулааны шугам сүлжээг үе шаттайгаар засварлана.
- 2.3.11 Аж ахуйн нэгж байгууллагын хаяг, рекламыг шинэчлэх, гадна орчиндоо гэрэлтүүлэгтэй болгох, айл өрхийн хашаа, барилга байгууламжуудын өнгө үзэмжийг сайжруулна.
- 2.3.12 Цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй, хүчдэл уналттай гэр хороололд трансформатор тавих, Бүрхээр багийн хуучирч муудсан 04 квт-ын шугамыг үе шаттайгаар шинэчлэх ажлыг зохих шатны байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, орон нутагт Цахилгаан эрчим хүчиний цагийн тарифт тоолуурыг нийтийн хэрэгцээнд нэвтрүүлнэ.



0000000008

- 2.3.13 “Цахим Цэцэрлэг” хөтөлбөрийг хэрэгжүүлж өндөр хурдны интернэтийн үйлчилгээнд сумын төвийн айл өрх бүрийг хамруулах, үнэ тарифыг бууруулах, мэдээлэл холбооны гурвалсан үйлчилгээтэй болгох талаар зохих шатны байгууллагад хандаж шийдвэрлүүлнэ.
- 2.3.14 Гэр хорооллын хүн амыг ундын цэвэр усаар хангах ажлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ.
- 2.3.15 Сумын төв болон Бүрхээр багийн гудамж талбайд өнгө үзэмж, хийц загвар сайтай хогийн савнууд байрлуулж, сумын төвд З газарт орчин үеийн нийтийн бие засах газар шинээр барина.
- 2.3.16 Бяслагийн үйлдвэрийн ажлыг дуусгаж ашиглалтад оруулан үйл ажиллагааг нь жигдрүүлэх
- 2.3.17 Хог ангилан ялгах цехийн үйл ажиллагааг жигдрүүлж, хогийг дарж, булж устгах /ландфил/ технологийг нэвтрүүлж, хогийн нэгдсэн цэгийг хашаажуулна.
- 2.3.18 Нийтийн халуун усны газар байгуулах, нэмэгдүүлэх санал санаачилгыг дэмжинэ.
- 2.3.19 Сумын төвийн ард хиймэл нуур байгуулах ажлын судалгааг хийж, ажлыг эхлүүлэх, экосистемийн тэнцвэрт орчин бий болгох, АЖ-ыг үзмэрийг нэмэгдүүлэх
- 2.3.20 Төмс хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалах иргэдэд жил тодорхой хэмжээний газар олгож эзэмшүүлнэ.
- 2.3.21 Газар зохион байгуулалтын төлөвлөлт, газар ашиглалтыг сайжруулж, газрын зөрчлийг арилгах ажлыг төлөвлөгөөтэйгөөр зохион байгуулж, газрын шинэтгэлийг эрчимжүүлэн, Монгол улсын иргэн бүрд газар өмчлүүлэх ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулна.
- 2.3.22 “Хийморь” цогцолборын тохижилтын ажлыг үе шаттай зохион байгуулах.
- 2.3.23 Нийтийн зар сурталчилгааны самбарыг бий болгоно.
- 2.3.24 “Хашаандаа сайхан амьдарья” төслийг сумандаа хэрэгжүүлэх, орчин дэвшилтэд технологийг ашиглан амьдрах орчноо сайжруулах айл өрхийг дэмжинэ.

#### 2.4 Төсөв санхүүгийн чиглэлээр

Улс, аймаг, сумын төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлж, хуримтлалын шинэ тогтолцоог бий болгон орцод суурилсан төсвөөс хөтөлбөрт суурилсан төсвийг бий болгон хэрэгжүүлж, төсвийн өргүй ажиллана.

- 2.4.1 Төсвийн орлогын төлөвлөлтийг үндэслэлтэй хийж, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулан, татвар төлөгчдийн тоог нэмэгдүүлж, албад тасгудтай хамтран татварын өр, авлагыг барагдуулах замаар татвар хураалтыг сайжруулан, улс, аймаг, орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлнэ.
- 2.4.2 Орон нутгийн болон тусгай шилжүүлгийн байгууллагуудын батлагдсан төсвийг зориулалтын дагуу хэмнэлттэй зарцуулж, төсвийн гүйцэтгэлд төрийн сангаас тавих хяналт шалгалтыг тогтмолжуулж, төсвийн үргүй зардал гаргахгүй ажиллана.

1720090014-070605

С.М

0000030309

- 2.4.3 Орон нутгийн төсвийн орлого зарлагын дунд хугацааны төлөвлөлтийг боловсруулж, сумын ИТХ-д өргөн барьж батлуулан хэрэгжилтийг зохион байгуулна.
- 2.4.4 Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэх хөрөнгө оруулалтын ажлуудыг олон нийтийн нээлттэй санал асуулга явуулан, ИНХ-аар хэлэлцүүлж, сумын ИТХ-д өргөн барих ажлыг хуулийн дагуу гүйцэтгэн, төсөл, хөтөлбөр, төсвийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт, зээлийг олон нийтэд ил тод нээлттэй хэлэлцүүлнэ.
- 2.4.5 Нягтлан бодогчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх давтан сургалтыг зохион байгуулж мэргэшсэн nyaгтлан бодогчдын тоо, чанарыг нэмэгдүүлнэ.

## 2.5 Байгаль орчны талаар хэрэгжүүлэх бодлого

Байгалийн баялгийг ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, хөрс, ус, агаарын бохирдоос сэргийлэх ажилд иргэдийн тавих хяналт, оролцоог нэмэгдүүлнэ.

- 2.5.1 Байгалийн нөөц баялгийг зүй зохистой ашиглуулах, хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг хуулийн дагуу гүйцэтгүүлнэ.
- 2.5.2 Ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөл, ААНБ-уудыг менежмент төлөвлөгөөний дагуу ойн санг зүй зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, хортон шавж, өвчний тархалтыг судлах, устгах ажлуудыг гүйцэтгүүлнэ.
- 2.5.3 Аж ахуйн нэгжүүдийн хавиаргагдсан модны хэмжээнээс хамаарч ойжуулалтын ажлыг жил бүрийн модны хуваарьтай уялдуулж хийж гүйцэтгэнэ.
- 2.5.4 Мод үргүүлгийн газар шинээр байгуулахад дэмжлэг үзүүлнэ.
- 2.5.5 Сумын нутаг дэвсгэрт усны эх үүсвэрийн тооллого явуулж, ус ашиглалтын байдлын түвшнийг тогтоон, усны мэдээллийн санг шинэчлэн байгуулна.
- 2.5.6 Ус цаг уурын станцад агаарын чанарын харуул ажиллуулан, агаарын шинжилгээ хийх, бохирдуулагч эх үүсвэрийн тооллогыг явуулж, бохирдлыг 50 хувиар бууруулна.
- 2.5.7 Байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, хяналт шалгалтыг тогтмолжуулан хууль бус үйлдлүүдийг таслан зогсоно.
- 2.5.8 “Чацааргана” дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- 2.5.9 Бүх нийтээр мод тарих ажлыг жилд 2 удаа зохион байгуулж, төв суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд иргэн, ААНБ-ийг идэвхтэй оролцуулна.
- 2.5.10 “Тэр бум мод” үндэсний хөдөлгөөнийг дэмжиж сумын хэмжээнд 10000 га-с дээш газарт мод тарина.
- 2.5.11 Аж ахуйн нэгж байгууллагын карьераын аж ахуй эрхлэх санал санаачилгыг дэмжих, түгээмэл тархацтай ашигт малтмалын байгалийн нөхөн сэргээлт хийлгэнэ.
- 2.5.12 Хэт нимгэн хэрэглээнээс гарсан нийлэг уутнаас татгалзаж цаасан болон даавуун уут хэрэглээнд нэвтрүүлэх санал санаачилгыг дэмжинэ.

**ГУРАВ. НУТГИЙН ЗАХИРГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН АЖИЛ  
ҮЙЛЧИЛГЭЭ**

1720096-11-178605

0000000010

### **3.1 Нутгийн захиргааны ажил үйлчилгээ**


**Нутгийн захиргааны ажил үйлчилгээг ил тод, нээлттэй, шуурхай, хариуцлагатай болгож, төр, иргэний харилцан итгэлцлийг бэхжүүлнэ.**

- 3.1.1 Төрийн үйлчилгээний ил тод, шуурхай байдлыг хангаж, хөтөч үйлчилгээг нэвтрүүлэн, төрийн албан хаагчийн ажлын хариуцлага ёс зүйг дээшлүүлнэ.
- 3.1.2 Төрийн албан хаагчийг гадаад, дотоодын хэрэгцээт сургалтад хамруулах, мэргэшүүлэх, ажиллах нөхцөлийг сайжруулна.
- 3.1.3 Багийн төвийн байрнуудын халаалт болон бохирын асуудлыг шийдвэрлэн, барилгуудыг засварлана.
- 3.1.4 Суманд “Иргэний мэдээллийн төв” байгуулж, иргэдийн санал бодлыг байнга сонсож төрийн бодлогод тусгана.
- 3.1.5 Мэдээлэл технологийг ашиглан цаасаар үйлддэг шат дамжлагыг бууруулах “Цахим засаглал” хөтөлбөрийг хэрэгжүүлж, ИТХ, ЗДТГ өөрийн гэсэн сайттай болно.
- 3.1.6 Төрийн архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулж, байгууллагуудын архив, албан хэрэг хөтлөлтийн ORG-AMS цахим программ нэвтрүүлнэ.
- 3.1.7 Улсын бүртгэлийн ажил үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай үзүүлэх боломж нөхцөлийг нэмэгдүүлнэ.
- 3.1.8 Эд хөрөнгө өмчлөх, эрхийн бүртгэлийн үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй болгох ажлыг дээд шатны байгууллагад уламжлан, шийдвэрлүүлнэ.
- 3.1.9 ЗДТГ-ын байр буюу Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилгыг шинээр барьж ашиглалтад оруулан шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.
- 3.1.10 Төрийн албан хаагчдын унаа, тавилга, эд хогшил, техник хэрэгслийг үе шаттайгаар шийдвэрлэнэ.

### **3.2 Хүний эрхийг хангах, хууль, эрх зүйн ажил үйлчилгээ**

**Хүний эрхийг хангах, хууль эрх зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх ажил үйлчилгээний үр нөлөөг сайжруулна.**

- 3.2.1 Хууль, эрх зүйн албан бус сургалт, сурталчилгааны ажлыг тогтмолжуулан, иргэдийн эрх зүйн боловсролыг сайжруулна.
- 3.2.2 Хүнийг эрхийг хангахад нутгийн захиргаа, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.
- 3.2.3 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журмыг сахиулах ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлж, сумын тодорхой цэгүүдэд төле камер байршуулна.
- 3.2.4 Бүрхээр багт цагдаа ажиллуулах талаар санал боловсруулж дээд шатны байгууллагад уламжилж шийдвэрлүүлнэ.
- 3.2.5 Архидан согтуурахаас зайлсхийх төрийн бодлогын орон нутаг дахь хэрэгжилтийг хангах зорилгоор “Архидалттай тэмцэх” хөтөлбөрийг иргэдийн саналд тулгуурлан боловсруулж хэрэгжүүлнэ.




00000000011

- 3.2.6 Согтууруулах ундаагаар үйлчилдэг ААНБ-ын үйл ажиллагаанд төрийн болон мэргэжлийн хяналтын шалгалтыг тогтмол зохион байгуулж, зөрчил дутагдлыг илрүүлэн арилгана.
- 3.2.7 Хүүхдийг ёс суртахуун, зан заншлын буруу зуршилд автхаас урьдчилан сэргийлэх, болзошгүй осол, гэмт үйлдлээс хамгаалахад чиглэсэн арга хэмжээг тогтмол зохион байгуулж хэвшүүлнэ.
- 3.2.8 Хөдөлгөөнт эргүүл ажиллуулж, цагдаагийн байгууллагын үйлчилгээний шуурхай байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх, явуулын постын бүхээг хийнэ.
- 3.2.9 Иргэд болон авлигатай тэмцэх төрийн бус байгууллагын сүлжээтэй хамтран авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын үр нөлөөг дээшлүүлж, авлигагүй орчин бүрдүүлж ажиллана.

### **3.3 Гамшгаас хамгаалах бодлого болон бусад**

- 3.3.1 Гамшгаас хамгаалах санг жил бүрийн төсөвт тусган, гамшгийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж, ой хээрийн түймэр, үер ус, халдварт өвчин, зуд, барилга байгууламжийн гол түймэр зэрэг болзошгүй аюулаас сэргийлэх, аюулыг бууруулах, бэлэн байдлыг хангах ажлыг хэрэгжүүлэх, гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тухай бүр тодотголыг хийж хэвшинэ.
- 3.3.2 Гамшиг осолтой тэмцэх чадавхыг нэмэгдүүлэх, техник хэрэгслээр хангах, харилцаа холбоог сайжруулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. /Зил 131 машин авах/
- 3.3.3 Объектын гол унтраах техник, хэрэгслээр хангах ажилд дэмжлэг үзүүлнэ.
- 3.3.4 Гадаад харилцаа, хамтын ажиллагааны чиглэл, хамрах хүрээг өргөтгөж, түншлэлийн харилцааг хөгжүүлнэ.
- 3.3.5 Хил хамгаалах байгууллагад ажиллаж буй хилчдийн эрүүл мэндийн байдал, амьдрах таатай орчныг бүрдүүлэх, ажил үүргээ гүйцэтгэхэд тулгардаг саад бэрхшээлийг арилгах талаар онцгой анхаарч “Цэцэрлэгийн хилчин” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.



**ХАМТЫН СЭТГЭЛ, ХИЧЭЭЛ ЗҮТГЭЛЭЭР ХӨГЖИН ДЭВЖИЦГЭЭ**

 0000000012